

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН ЗАХИРАМЖИЙН
06 ДУГААР САРЫН БИЕЛЭЛТ**

2020 оны 06 дугаар сарын 30

Багануур дүүрэг

№	Ирсэн огноо	Батлагдсан огноо	Дугаар	Биелэлт
1	2019.06.28	2019.06.21	A/619	Паркийн Үйлдвэрийн албан конторын барилгын гадна болон дотор инженерийн шугам сүлжээний зураг төсөл боловсруулагдаж, дүүргийн хангагч байгууллагуудтай зөвшилцөн магадлалаар хянагдан баталгаажсан. Зураг төслийн нэгдсэн дүгнэлт хүлээгдэж байна.
2	2019.10.11	2019.10.09	A/1054	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн системийг ашиглах журмын хэрэгжилтийг ханган ажилласан ба “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-т 2020 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар хариутай 6, хариугүй 3 бичиг нийт 9 албан бичиг ирсэн ба хариутай бичгийн шийдвэрлэлт, хариугүй бичгийн хаалт тус бүр 100 хувьтай байна. “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-аас ААНБ-уудад нийт 27 хариугүй бичиг явуулсан ба шийдвэрлэлт 100 хувьтай байна.
3	2020.01.28	2020.01.27	A/108	<ul style="list-style-type: none"> - 1.6 дугаар заалтын дагуу Албан хаагчдын амны хаалтын хэрэглээг хэвшүүлэн, өглөө бүр ажлын байранд чийгтэй цэвэрлэгээг хийж, хаалганы бариулыг 2 цаг тутамд спиртээр тогтмол ариутгаж, 7 хоног бүрийн Баасан гарагт их цэвэрлэгээг хийж байна. - Захирамжийн биелэлтийг 7 хоног бүрийн пүрэв гаригт zendmaal@gmail.com цахим хаягт илгээн тайлагнаж байна. - Мөн ЭМЯ болон дүүргийн ЭМТ-өөс өгч байгаа зөвлөмж, корона вирусын халдвараас урьдчилан сэргийлэх талаарх мэдээлэл, цаг үеийн мэдээг өглөө бүр албан хаагчдад танилцуулан, www.baganuur-itp.mn цахим хуудсанд тогтмол байршуулж байна.
4	2020.02.07	2020.02.07	A/168	3 дугаар заалтын дагуу дүүргээс зохион байгуулагдаж буй их цэвэрлэгээнд идэвхитэй оролцож байгаа ба захирамжийн биелэлтийг 14 хоног тутам НЗДТГ-ын ХШ,ҮХ-т тайлагнан ажиллаж байна.
5	2020.02.14	2020.02.13	A/191	- Захирамжийн дагуу НОК-ын орлогч даргын баталсан “Шинэ төрлийн корона вирус /COVID-19/-ын өвчлөлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, иргэдэд зөвлөмж мэдээлэл өгч, эргүүлээр ажиллах хуваарь”-ийн дагуу 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдрөөс 06 дугаар сарын 11-ний өдрийг дуустал баталсан хуваарийн дагуу явган эргүүлийн ажилд хяналт тавьж, дүн мэдээг боловсруулан нэгтгэж, орой бүр 21:00 цагт Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Шуурхай штабт, Нийслэлийн Эрүүл мэндийн газарт ubhealth2020@gmail.com цахим хаягаар, дүүргийн онцгой комисст 7021101 утсаар, эргүүлээр ажилласан тоон мэдээг 7 хоногоор нэгтгэж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэст 7 хоног бүрийн баасан гарагт battsoojubcity@gmail.com цахим хаягаар тус тус хүргүүлэн ажилласан.

				<ul style="list-style-type: none"> - Нийслэлд ажилладаг ажилтнууд, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын заавраар нийслэлийн Гүнт дэх хяналтын цэг дээр хотоос гарч, орж буй иргэдээс эрүүл мэндийн асуумж авч, орж буй иргэд, тээврийн хэрэгслийг бүртгэх ажлыг ажлын бус өдөр буюу дөрвөн Бямба гарагт өдрийн 12 цагаар гүйцэтгэсэн. Энэ хугацаанд гарах хөдөлгөөний 600 гаруй, орох хөдөлгөөний 400 тээврийн хэрэгсэл, 1500 гаруй иргэн хамрагдсан бүртгэл хийсэн. - НЗДТГ-аас 2020 оны 06 дугаар сарын 04-ны өдөр ирүүлсэн албан бичгийн дагуу шинэ төрлийн корона вирус /covid-19/-ийн өвчлөлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, иргэдэд зөвлөмж мэдээлэл өгч ажилласан эргүүлийн ажлын тайланг боловсруулан 2020 оны 06 дугаар сарын 05-ны өдөр 105 дугаартай албан бичгээр илгээсэн.
--	--	--	--	--

ХЯНАСАН:

"БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛТ ТЕХНОЛОГИЙН ПАРК"

ОНӨТҮГ-ЫН ДАРГА



Ч.ЭЛБЭГСАЙХАН

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Sanvit

Б.НОМИНЗУЛ